СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024 | V



www.sukhbaatar.nso.mn

www.1212.mn

Баруун-Урт сум
2024 он

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024
5 сар

Баруун-Урт сум

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- ‘Төл’ гэсэн нь төлөвлөгөө, ‘Гүйц’ гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		

a^x x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь

▼ ▲ өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

• мянга	=1000	• $м^2$	метр квадрат
• сая	$=10^6$	• $км^2$	километр квадрат
• тэрбум	$=10^9$	• $м^3$	метр куб
• см	сантиметр	• мл	миллилитр
• дм	дециметр	• л	литр
• м	метр	• г	грамм
• км	километр	• кг	килограмм
• мян.	мянга	• цн	центнер
• %	хувь	• т	тонн
• кВт.ц	киловатт цаг	• ш	ширхэг
• ккал	килокалори		

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 3

Үндсэн үзүүлэлтүүд 5

I Хүн ам 6

II Хөдөлмөр 8

III Нийгмийн халамж 10

IV Эрүүл мэнд 11

V Гэмт хэрэг 14

VI Мөнгө, банк 16

VII Орон нутгийн төсөв 18

VIII Үнэ 19

IX Хөдөө аж ахуй 22

X Аж үйлдвэр 27

Хавсралт хүснэгтийн жагсаалт 31

Хавсралт хүснэгтүүд 32

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	Ц.Азжаргал
I Хүн ам	Ц.Азжаргал
II Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III Нийгмийн халамж	Ц.Азжаргал
IV Эрүүл мэнд	Ц.Азжаргал
V Гэмт хэрэг	Б.Сумъяа
VI Мөнгө, Банк	Б.Сумъяа
VII Орон нутгийн төсөв	Ц.Азжаргал
VIII.а Хэрэглээний үнэ	Б.Сумъяа
VIII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	О.Ундрах
IX Хөдөө аж ахуй	О.Ундрах
X Аж үйлдвэр	Э.Анхцэцэг

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Ц.Азжаргал

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 I-V	2023 I-V	2024 I-V
Төрсөн хүүхэд	хүн	410 -29.9	545 32.9	451 -17.3
Нялхасын эндэгдэл	хүн	5 5.0**	3 -40.0	3
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	495 .22.5	-	175
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	3 517 8.1 **	562 -80.0	380 -32.4
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	274 73.4	219 -20.1	215 -1.8
Хэрэгт холбогсод	хүн	217 2.2**	98 -54.8	141 30.5
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	106.4 2.4	104.1 -2.2	103.0 -1.1
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	141.2 -6.1	140.0 -0.9	158.9 11.9
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	192.8 35.4	202.8 5.2	256.6 21.0
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	27.6 -8.0	33.1 19.9	35.1 6.0
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	24.9 -14.7	18.5 -25.7	27.7 49.7
Төллөсөн хээлтэгч	тол	1 524 772 12.7	1 517 285 -0.5	540 046 -64.4
Ингэ	тол	1 161 28.7	1 046 .9.9	695 -33.6
Гүү	тол	77 470 25.8	75 413 -2.7	32 929 -56.3
Үнээ	тол	82 249 25.6	78 452 -4.6	31 357 -60.0
Эм хонь	тол	865 267 13.2	874 503 1.1	319 192 -63.5
Эм ямаа	тол	498 625 8.2	487 871 -2.2	155 873 -68.1
Бойжуулсан төл	тол	1 515 943 12.8	1 108 419 -26.9	434 526 -60.8
Ботго	тол	1 152 29.7	993 -13.8	656 -33.9
Унага	тол	77 055 26.3	59 296 -23.0	30 540 -48.5
Тугал	тол	81 793 25.9	64 331 -21.3	29 024 -54.9
Хурга	тол	861 572 13.3	642 388 -25.4	254 381 -60.4
Ишиг	тол	494 371 8.3	341 4116 -30.9	119 925 -64.9
Том малын зүй бусын хорогдол	тол	10 098 -72.9	552 216 54.7**	1 815 485 3.3**
Тэмээ	тол	21 -8.7	92 4.4**	299 3.3**
Адуу	тол	1 187 -18.0	25 405 21.4**	71 476 2.8**
Үхэр	тол	1 160 -67.0	28 219 24.3**	135 025 4.8**
Хонь	тол	3 727 -75.5	260 468 69.9**	1 061 622 4.1**
Ямаа	тол	4 003 -76.5	238 032 59.5**	547 063 2.3**
Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал	тол	119 23.8**	83 -30.3	83
Үхэр	тол	21	-	20
Хонь	тол	45	83 84.4	54 -34.9
Ямаа	тол	53	-	9
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	20.8 3.0	90.6 -4.41**	100.5 10.9
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	105.5 -2.9	206.4 95.6	131.9 -36.1

Тайлбар: ** дахин

ХҮН АМ, жил бүрийн эхний 5 сард



Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 17.3 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2024 оны эхний 5 сард 448 эх амаржиж, 451 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 94 (17.3%)-аар, төрсөн хүүхэд 94 (17.3%)-аар тус тус буурчээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 5 сард



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оноос 1.5 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 5 сард



2024 оны эхний 5 сард нас баралт 130 болж, өмнөх оноос 12 (8.5%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 6.8, нас баралт 2.0, ердийн цэвэр өсөлт 4.8 байна.

1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР, бүртгэлтэй ажил хайгч иргэд

2024 оны 5 дугаар сар

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, насны бүлгээр, тоогоор

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 20.7 хувиар өслөө.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2024 оны 5 дугаар сарын эцэст 175 болсны 61 (34.9%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд 2023 оны 12 дугаар сарын эцсээс 127 (42.1%) хүнээр буурсан байна.

Эхний 5 сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 348 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 121 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 135 (77.1%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 1 (0.7%) нь магистр, доктор, 20 (13.8%) нь бакалавр, 7 (4.8%) нь тусгай дунд, 66 (45.5%) нь бүрэн дунд, 16 (11.0%) нь мэргэжлийн анхан шат, суурь, бага боловсролтой, 3 (2.1%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшингээр, 5 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ өмнө оноос 277 (28.8%) хүнээр буурчээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2024 оны эхний 5 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1454 хүн хамрагдсан нь өмнөх оноос 94 (6.9%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 2 448.2 сая төгрөг болж 514.3 (26.6%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2024 оны эхний 5 сард 2469 хүн хамрагдсаны 51.8 хувь нь асаргааны тэтгэмжид, 48.2 хувь нь онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид нийт 4 623.1 сая төгрөг олгосон нь өмнөх оноос 1 748.6 (60.8%) сая төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, жил бүрийн эхний 5 сар

Үзүүлэлт	2022.I-V		2023.I-V		2024.I-V	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**24 115**	**4 741.1**	**22 792**	**5 040.7**	**48 355**	**19 027.7**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	6 537	2 831.4	4 499	2 874.5	4 608	4 623.1
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 313	1 815.5	1 360	1 933.9	1 454	2 448.2
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 084	841.1	2 130	855.9	2 469	2 135.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ	50	30.5	47	37.7	-	-
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	3 090	144.3	962	47.0	685	39.3
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 347	704.5	5 568	722.2	5 697	732.9
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 569	141.9	4 594	169.4	5 061	106.8
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	2	0.3	5	0.6	6	0.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	285	44.7	336	71.0	450	87.5
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 541	794.8	4 699	957.4	4 248	895.2
Хүүхдийн мөнгөн тэтгэмж	-	-	-	-	24 947	12 317.6
Насны хишиг	2 836	223.8	3 091	245.6	3 338	263.7

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан хүний тоо буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн эхний 5 сард

Эрүүл мэнд

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид



2023 I-V **7 048**

2024 I-V **7 800**

10.7% ↑

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2023 I-V **562**

2024 I-V **380**

32.4% ↓

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2023 I-V	3
	2024 I-V	3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2023 I-V	3
	2024 I-V	2

2024 оны эхний 5 сарын байдлаар эхийн эндэгдэл 1 гарчээ..

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2024 оны эхний 5 сард 448 эх амаржсан нь өмнөх оноос 94 (17.3%)-аар буурсан байна. Нийт амаржсан эхийн 0.5 хувь нь гэртээ төрсөн байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 412 (91.3%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амалсан, 17 (3.8%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн эхний 5 сард

Үзүүлэлт	2022 I-V	2023 I-V	2024 I-V	2024 I-V / 2023 I-V
	тоо			хувь
Амаржсан эх	411	542	448	82.7
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	376	528	425	80.5
Гэрийн төрөлт	2	3	2	66.7
Амьд төрсөн хүүхэд	410	545	451	82.8
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	376	514	412	80.2
төрөлхийн гажигтай төрсөн	1	3	5	166.7
2500 граммаас доош жинтэй төрсөн	15	13	17	130.8
Амьгүй төрсөн хүүхэд	3	2	-	-
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	7. 3	3. 6	-	-

2024 оны эхний 5 сард нас баралтын 130 тохиолдол бүртгэгдсэний 17 (13.1%) нь осол гэмтлийн улмаас, 31 (23.8%) нь хорт хавдарын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 5 сард

Үзүүлэлт	2022 I-V	2023 I-V	2024 I-V	2024 I-V / 2023 I-V
	тоо			хувь
Нас баралт	135	142	130	91.5
Эмнэлгийн нас баралт	34	23	27	117.4
Эхийн эндэгдэл	-	-	1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	11	29	17	58.6
Хорт хавдрын өвчлөл нас баралт	42	30	31	103.3
0-1 насны эндэгдэл	5	3	3	100.0
1-5 хүртэлх насны эндэгдэл	5	3	3	100.0

Халдварт өвчнөөр өвлөгчид 2024 оны эхний 5 сард 380 болж, өмнөх оны мөн үеэс 182 (32.4%)-аар буурахад ковид 19 өвчний халдварын тохиолдол буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 5 сар

Халдварт өвчин	2022 I-V	2023 I-V	2024 I-V	Өсөлт	
	хүн			тоо	хувь
Бүгд	**3 517**	**562**	**380**	**- 182**	**67.6**
Вируст гепатит	2	2	1	- 1	50.0
Гар хөл амны өвчин	1	106	78	- 28	73.6
Бруцеллёз	1	-	1	1	-
Цусан суулга	2	2	9	7	4.5 [1]
Салхинцэцэг	5	175	128	- 47	73.1
Энтервируст халдвар	-	77	70	- 7	90.9
Гахайн хавдар	-	2	1	- 1	50.0
Улаан эсэргэнэ	-	12	-	-	-
Ёлом	-	1	-	- 1	-
Салмонеллт	-	1	10	9	10.0 [1]
Толбот чичрэг		4	-	- 4	-
Ecoli-оор/ A04.4/	-	-	3	3	-
Сүрьеэ	32	32	23	- 9	71.9
Тэмбүү	15	15	15	0	100.0
Трихомониаз	36	29	13	- 16	44.8
Заг	21	21	28	7	133.3
Ковид-19	3 402	83	-	- 83	-

Харин цусан сууулга халдвараар өвчлөгчид 9 (4.5 дахин)-аар, салмонеллт 10 (9.0 дахин)-аар, заг хүйтэнээр өвчлөгчид 289 (33.3%)-аар нэмэгдсэн бөгөөд шинээр ecoli-оор халдарын 3 тохиолдолд тус тус бүртгэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны эхний 5 сарын байдлаар 114.9 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 2.2 (2.0%) мянган хүнээр буурч, 7.8 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 17.9 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 6.3 (25.9%) мянган хүнээр буурчээ.

Түргэн тусламжийн дуудлага 7.2 мянган удаа гарсны 1.6 (21.8%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 0.2 мянган (16.4%) удаагийн дуудлагаар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

ГЭМТ ХЭРЭГ, 2024 оны эхний 5 дугаар сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2023 I-V	2024 I-V	
219	215	1.8% ↓

Хөнгөн хэрэг
156

Хүнд хэрэг
59

Илрүүлэлтийн хувь
51.9%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
74

Нас барсан хүн
6

Хохирол сая төг
879.8

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
8

Согтуугаар
90

Ял шийтгэгдэж байсан
29

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 4 (1.8%)-өөр буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 74 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 879.8 сая төгрөгийн хохирол учирсны 32.3 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 141 хүн холбогдон сэжиглэгдсэний 90 (36.2%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ.
Нийт 175 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 60 (25.5%) хүнээр буурсан байна. Шүүхийн шийдвэрээр 97 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.
Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 51.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 24.5 нэгжээр өссөн байна.

Зураг 5. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ, ЗЭЭЛ, 2024 оны 5 сард

Нийт зээлдэгчийн тоо

2023 V **32 298**

2024 V **34 785**

Зээл 2024 V

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл **256.3** тэрбум төгрөг

1.5 тэрбум төгрөг Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл

1.4 тэрбум төгрөг Чанаргүй зээл

Нийт **158.9** тэрбум төгрөг

Хугацаатай **137.4** тэрбум төгрөг

Хугацаагүй **21.5** тэрбум төгрөг

Салбар нэгжийн тоо **35**

АТМ-ны тоо **34**

Ажилтнуудын тоо **210**

Карт эзэмшигчийн тоо **58 427**

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 5 сарын байдлаар 1.4 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.6 хувийг эзэлж байна.

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 256.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 8.4 (3.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 53.8 (20.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 158.9 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 0.5 (0.3%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 18.9 (11.9%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт хадгаламжийн 86.5% нь хугацаатай, 13.5 % нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 6. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАДАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 13.6 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2024 оны эхний 5 сарын байдлаар 35.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2.0 (6.0%) тэрбум төгрөгөөр өсч, төсвийн зарлага санхүүжилт 27.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 9.2 (49.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 7. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төг



Аймгийн нийт төсвийн 37.5 хувийг орон нутгийн төсвийн орлого, 13.9 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 13.8 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 17.8 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 17.0 хувийг урьд оны үлдэгдэл тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Аймгийн төсвийн мэдээг Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгээ боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН УЛСЫН ИНДЕКС, бүлгээр, хувиар, 2024 оны 5 дугаар сард



Тайлбар: Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.7 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 5 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.0 хувь, өмнөх оны эцсээс 3.0 хувь, өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна.

ЗУРАГ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 11.5 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 7.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 6.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.3 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 15.7 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 5 дугаар сард өмнөх оны эцсээс 3.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 0.1 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 5.0 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.7 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 15.6 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 9.6 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 5 дугаар сард өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ

4.5 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 5. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2024 оны 5 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	2024 V / 2023 V	2024 V / 2023 XII	2024 V / 2024 IV
Ерөнхий индекс	106.0	103.0	100.5
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	111.5	107.3	101.5
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	103.0	100.7	100.0
Хувцас, бөс бараа, гутал	107.5	101.6	100.3
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	102.0	100.1	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	106.9	105.0	100.1
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	105.3	101.7	100.0
Тээвэр	99.6	98.0	99.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	102.8	102.5	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	115.7	115.6	104.5
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	109.6	109.6	100.0
Бусад бараа, үйлчилгээ	105.8	102.8	101.6

ЗУРАГ 9. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2024 оны 5 дугаар сард өмнөх сараас 3.6 хувиар өсөхөд хонь, ямааны махны үнэ дунджаар 3.2 хувь, үхрийн махны үнэ 9.6 хувь, адууны махны үнэ 2.3 хувиар тус тус өссөн байна. Мөн өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар өсөхөд үхрийн махны үнэ дундажаар 24.8 хувь, хонь, ямааны махны үнэ 17.3 хувь, адууны махны үнэ 12.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.3 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2024 оны 05 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 0.9 сая төгрөг болж, 150 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.3 сая төгрөг болж, 239,1 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 0.9 сая төгрөг болж, 12.2 мянган төгрөгөөр тус тус буурч, эр хонины үнэ 232.9 мянган төгрөг болж, 30.6 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 146.3 мянган төгрөг болж, 15.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 10. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5 сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2024 оны 05 дугаар сард Түмэнцогт суманд хамгийн их буюу 2.2 сая төгрөг, Түвшинширээ суманд хамгийн бага буюу 900.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 11. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2024 оны 5 сард, мянган төгрөг



Хивэгний үнэ 2024 оны 05 дугаар сард 33.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 (4.2%) мянган төгрөгөөр өссөн бол 1 боодол өвсний дундаж үнэ 8.0 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 14.5 (64.4%) мянган төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 12. ӨВС, ХИВЭГНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 5 сард



<u>Ойлголт, тодорхойлолт:</u>

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

<u>Тооцох аргачлал:</u>

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

МАЛ АЖ АХУЙ 2024 оны эхний 5 сард



Мал төллөлт аймгийн хэмжээнд 29.0 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2024 оны 5 дугаар сарын байдлаар оны эхний төллөх насны 1859.6 мянган хээлтэгч малын 540.0 мянга (29.0%) нь төлөжээ. Гүүний 25.8 хувь, үнээний 24.7 хувь, ингэний 23.1 хувь, эм хонины 31.1 хувь, эм ямааны 27.1 хувь нь төллөсөн байна.

ЗУРАГ 13. ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, мянган толгой



Бойжуулсан төл 2024 оны 5 дугаар сарын байдлаар 0.4 сая болж, бойжилтын хувь 80.4% байна. Гарсан унаганы 92.7 хувь, тугалын 92.6 хувь, ботгоны 94.4 хувь, хурганы 79.6 хувь, ишигний 76.9 хувь нь бойжжээ.

Аймгийн хэмжээнд 105.9 мян.толгой төл мал хорогдсоноос унага 2.4 мян.толгой, тугал 2.3 мян.толгой, ботго 39 толгой, хурга 65.0 мян.толгой, ишиг 36.1 мян.толгой төл мал хорогдоод байна.

Оны эхний малын 47.0 хувь буюу 1815.5 мянган толгой том мал 2024 оны эхний 5 сарын байдлаар зүй бусаар хорогдлоо.

ЗУРАГ 14. ХОРОГДСОН МАЛЫН ТОО, сумаар, мянган толгой



Хорогдлыг малын төрлөөр авч үзвэл 71.5 мянган толгой адуу, 135.0 мянган толгой үхэр, 299 толгой тэмээ, 1061.6 мянган толгой хонь, 547.1 мянган толгой ямаа байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, жил бүрийн эхний 5 дугаар сар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг



Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг



Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 44.2 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 100.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.9 (10.9%) тэрбум төгрөгөөр өслөө.

ЗУРАГ 15. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 83.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.5 (11.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд чулуун болон хүрэн нүүрс олборлолт 6.3 (44.8%) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 9.7 (22.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, төмрийн хүдрийн баяжмал өмнөх оноос 78.4 хувиас 2 дахин өсчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт хэрчсэн гурил, малын мах, дээл тэрлэг зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 15.8 хувиас 69.8 хувь хүртэл өссөн байна.

ХҮСНЭГТ 6. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2023 V	2023 I-V	2024* V	2024* I-V	2024* I-V / 2023 I-V
		тоо				хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс	мян.т	81.769	290.417	176.7	518.1	178.4
Цайрын баяжмал	мян.т	5.82	31.8	6.3	30.8	96.9
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	1.76	1.8	3.6	3.6	2.0[1]
Хайлуур жонш	мян.т	0.6	3.987	0.7	3.0	76.3
Хайлуур жоншны баяжмал	мян.т	3.524	9.6	1.8	9.1	94.9
Боловсруулах аж үйлдвэр						
Талх	т	54.5	240.7	36.9	161.2	67.0
Нарийн боов	т	7.0	31.3	4.1	20.5	65.3
Хэвийн боов	т	1.0	45.3	0.4	21.0	46.3
Бялуу	т	0.5	2.9	0.4	2.2	76.9
Хэрчсэн гурил	т	7.4	31.7	9.8	36.7	115.8
Малын мах	т	99.6	357.7	-	493.4	137.9
Цэвэр ус	мян.л	58.9	304.4	65.4	291.3	95.7
Бууз, банш	т	5.15	9.8	0.3	5.5	56.6
Монгол дээл,тэрлэг	ш	152	1 010	213	1 715	169.8
Бэлтгэлийн хувцас /өмд, цамц/	ш	-	15	-	-	-
Гутал	хос	11	290	14	107	36.9
Бетон зуурмаг	м3	1 048.0	2 154.8	990	1 140.0	52.9

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2024 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 131.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 74.5 (36.1%) тэрбум төгрөгөөр буурлаа. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 77.1 (40.3%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сая.төг

Салбар	2023 I-V	2024*		2024* I-V / 2023 I-V
		I-V	Гадаад	
	тоо			хувь
Нийт дүн	**206 406.9**	**131 875.9**	**116 900.8**	**63.9**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	191 238.7	114 143.1	113 111.9	59.7
Боловсруулах аж үйлдвэр	5 942.2	5 845.0	3 788.9	98.4
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	8 360.6	10 490.6	-	125.5
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	865.5	1 397.1	-	161.4

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 74.5 (36.1%) тэрбум төгрөгөөр буурахад металлын хүдэр олборлолтын салбарын борлуулалт 73.1 (48.8%) тэрбум төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 7.5 (37.1%) буурсан нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 16. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг

Гадаад зах зээлд 2024 оны эхний 5 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 116.9 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 113.1 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 20.8 хувийг нүүрс олборлолтын салбар, 67.9 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 11.3 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувираа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар, боловсрол, насны бүлгээр

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV ЭРҮҮЛ МЭНД

IV.1 ЭРҮҮЛ МЭНД

IV.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

IV.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

V ГЭМТ ХЭРЭГ

V.1 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ

V.2 БҮРТГЭГДСЭН ХЭРЭГ, сумаар

V.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД

V.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИД, сумаар

VI МӨНГӨ, БАНК

VI.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

VII ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

VII.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

VII.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

VII.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар

VII.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

VIII ҮНЭ

VIII.а.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

VIII.а.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ

VIII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар

IX ХӨДӨӨ АЖ АХУЙ

IX.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, малын төрлөөр

IX.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумаар

IX.3 ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр

IX.4 ТӨЛ БОЙЖИЛТ, сумаар

IX.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр

IX.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумаар

IX.7 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, малын төрлөөр

IX.8 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, сумаар

X АЖ ҮЙЛДВЭР

X.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

X.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

X.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2022		2023		2024	2024 V / 2023 V
	V	XII	V	XII	V	
	тоо					хувь
Нийт дүн	**495**	**363**	**-**	**302**	**175**	**-**
Асгат	9	2	-	2	9	-
Баяндэлгэр	8	4	-	8	-	-
Дарьганга	34	3	-	3	1	-
Мөнххаан	6	36	-	83	1	-
Наран	5	10	-	4	3	-
Онгон	2	8	-	2	-	-
Сүхбаатар	18	19	-	7	6	-
Түвшинширээ	72	72	-	3	5	-
Түмэнцогт	6	11	-	2	3	-
Уулбаян	9	10	-	26	2	-
Халзан	-	1	-	-	-	-
Эрдэнэцагаан	55	12	-	33	20	-
Баруун-Урт	271	175	-	129	125	-

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
	тоо															
Нийт дүн	**175**	**61**	**-**	**23**	**10**	**23**	**70**	**26**	**19**	**4**	**17**	**52**	**66**	**35**	**4**	**1**
Асгат	9	7	-	2	-	-	4	2	1	-	-	4	4	1	-	-
Баяндэлгэр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	1	-	-	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
Мөнххаан	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-
Наран	3	2	-	1	-	-	1	1	-	-	1	2	-	-	-	-
Онгон	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Сүхбаатар	6	3	-	2	1	1	1	1	-	-	-	2	3	1	-	-
Түвшинширээ	5	2	-	1	-	-	-	1	1	2	-	1	4	-	-	-
Түмэнцогт	3	3	-	-	-	2	1	-	-	-	1	1	-	1	-	-
Уулбаян	2	-	-	-	-	1	-	-	1	-	-	2	-	-	-	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	20	-	-	1	3	14	2	-	-	-	1	2	5	12	-	-
Баруун-Урт	125	44	-	16	6	5	60	20	16	2	13	37	50	20	4	1

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2022		2023		2024	2024 I-V / 2023 I-V
	I-V	I-XII	I-V	I-XII	I-V	
	тоо					хувь
Нийт дүн	**832**	**2 390**	**581**	**1 870**	**348**	**59.9**
Асгат	23	126	13	70	13	100.0
Баяндэлгэр	11	30	3	33	-	-
Дарьганга	77	136	14	96	9	64.3
Мөнххаан	13	103	4	96	17	4.3 [1]
Наран	34	137	29	76	21	72.4
Онгон	6	41	20	135	1	5.0
Сүхбаатар	34	161	53	106	7	13.2
Түвшинширээ	109	355	124	184	8	6.5
Түмэнцогт	25	64	3	44	5	166.7
Уулбаян	15	82	18	88	2	11.1
Халзан	6	33	-	31	2	-
Эрдэнэцагаан	62	95	16	171	36	2.3 [1]
Баруун-Урт	417	1 027	284	740	227	79.9

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2022		2023		2024	2024 I-V / 2023 I-V
	I-V	I-XII	I-V	I-XII	I-V	
	тоо					хувь
Нийт дүн	**84**	**761**	**46**	**764**	**121**	**2.6** [1]
Асгат	10	104	12	62	3	25.0
Баяндэлгэр	1	6	-	22	-	-
Дарьганга	7	55	4	73	8	2.0 [1]
Мөнххаан	1	29	1	9	24	24.0 [1]
Наран	17	91	4	35	18	4.5 [1]
Онгон	-	17	8	97	1	12.5
Сүхбаатар	-	56	-	43	1	-
Түвшинширээ	9	153	-	48	3	-
Түмэнцогт	2	21	-	32	-	-
Уулбаян	2	38	-	44	-	-
Халзан	4	24	-	31	2	-
Эрдэнэцагаан	2	11	4	114	18	4.5 [1]
Баруун-Урт	29	156	13	154	43	3.3 [1]

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮН, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, сумаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо					Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар							
	2023 I-V	2024 I-IV				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Боловсруулах аж үйлдвэр	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Урлаг, үзвэр, тоглоом наадам
		Бүгд	Үүнээс										
			Байнгын	Түр	Улирал								
	тоо												
Нийт дүн	**-**	**49**	**29**	**17**	**3**	**17**	**1**	**2**	**1**	**17**	**8**	**1**	**2**
Асгат	-	2	2	-	-	-	-	-	-	-	2	-	-
Дарьганга	-	11	8	1	2	2	-	-	-	1	6	-	2
Наран	-	17	1	16	-	-	-	-	-	16	-	1	-
Эрдэнэцагаан	-	19	18	-	1	15	1	2	1	-	-	-	-

III. НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.1 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2022 I-V		2023 I-V		2024 I-V	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**24 117**	**4 741.4**	**22 792**	**5 040.7**	**48 355**	**19 027.7**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	**6 537**	**2 831.4**	**4 499**	**2 874.5**	**4 608**	**4 623.1**
Нийгмийн халамжийн тэтгэвэр	**1 313**	**1 815.5**	**1 360**	**1 933.9**	**1 454**	**2 448.2**
Нийгмийн халамжийн тэтгэмж	**2 084**	**841.1**	**2 130**	**855.9**	**2 469**	**2 135.6**
Асаргааны тэтгэмж	**1 078**	**465.0**	**1 073**	**477.7**	**1 279**	**1 670.7**
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	608	232.6	193	78.7	212	283.9
Байнгын асаргаа шаардлагтай ахмад настныг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	200	79.6	619	243.5	783	990.4
Байнгын асаргаа шаардлагтай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэд олгох тэтгэмж	226	133.1	222	136.7	247	333.7
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	18	8.0	17	8.2	15	28.9
Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	5	3.7	7	4.1	8	13.5
Хүүхэд, төрөл садангүй ганц бие ахмад настан болон ХБ иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалах	21	8.0	15	6.5	14	20.3
